

ТА ҮЙЛЧИЛГЭЭГ АВАХЫН ӨМНӨ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ БОЛОН НУУЦЛАЛЫН БОДЛОГОТОЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН ТОХИОЛДОЛД “БҮРЭН ТАНИЛЦАЖ, ОЙЛГОЖ, ЗӨВШӨӨРЧ БАЙНА” ГЭСЭН ТОВЧИЙГ ДАРНА УУ. ХЭРЭВ ТА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХГҮЙ БАЙГАА БОЛ “БУЦАХ” ТОВЧИЙГ ДАРЖ СИСТЕМЭЭС ГАРНА УУ.

Энэхүү “Стор пэй” үйлчилгээний нөхцөлийг Монгол Улсад бүртгэлтэй “Стор пэй” ХХК /цаашид “компани” гэх/ болон иргэн /цаашид “хэрэглэгч” гэх/ нарын хооронд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрийг “Storepay” аппликейшн /цаашид “платформ” гэх/-ээр дамжуулан хуваарийн дагуу хуваан төлөх үйлчилгээг компаниас хэрэглэгчид үзүүлэхтэй холбогдсон харилцаанд баримтлах бөгөөд компаниас хэрэглэгч таны хувийн мэдээллийг хүлээн авах, хадгалах, уг үйлчилгээний нөхцөлд заасан зорилгоор ашиглах, түүнд боловсруулалт хийх улмаар худалдан авалтын төлбөрийг хуваан төлөх үйлчилгээний эрхийг олгох эрх зүйн үр дагавар бүхий хэлцэл болно.

Нэг.Ерөнхий зүйл

1.1. “Стор пэй” ХХК нь “STOREPAY” аппликейшнээр дамжуулан хэрэглэгчид бараа, бүтээгдэхүүн үйлчилгээг төлбөрийн хуваарийн дагуу хуваан төлөх үйлчилгээг үзүүлэх, үүнтэй холбоотой бусад харилцааг энэхүү үйлчилгээний нөхцөлөөр зохицуулна.

1.2. Дээрх үйлчилгээг үзүүлэхтэй холбоотойгоор компаниас хэрэглэгчийн хувийн мэдээллийг хүлээн авах, хадгалах, уг үйлчилгээний нөхцөлд заасан зорилгоор ашиглах, түүнд боловсруулалт хийх улмаар худалдан авалтын төлбөрийг хуваан төлөх үйлчилгээний эрхийг олгох эрх зүйн үр дагавар бүхий хэлцэл болно.

1.3. Компани нь үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхийг дангаар эдлэх бөгөөд уг өөрчлөлтийн талаар хэрэглэгчийн бүртгүүлсэн цахим шуудан болон Платформоор дамжуулан хэрэглэгч нарт мэдэгдэнэ.

1.4. Үйлчилгээний нөхцөлийн өөрчлөлтийг мөрдөж эхлэх хугацаа болон үндсэн агуулгыг дурдана.

1.5. Хэрэглэгч үйлчилгээний нөхцөлд орсон өөрчлөлтийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд энэ талаараа и-мэйлээр мэдэгдэж Үйлчилгээний эрхийг цуцлуулах эрхтэй.

1.6. Үйлчилгээний нөхцөлд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.6.1. “Стор пэй аппликейшн” гэж хэрэглэгчийн ухаалаг гар утас, бусад төхөөрөмжид татан авч, хэрэглэгчээр бүртгүүлэн, Компанийн санал болгож буй үйлчилгээнээс сонгон, Стор пэй үйлчилгээг авах эрх үүсэж, хуваан төлөх үйлчилгээ авах зориулалт бүхий “StorePay” нэртэй аппликейшн буюу цахим программ хангамжийг хэлнэ.

1.6.2. “Хэрэглэгч” гэж дараах шаардлагыг хангасан хүнийг ойлгоно. Үүнд:

Нийгмийн даатгалын шимтгэл төлдөг;

Тогтмол орлоготой, чанаргүй болон хуацаа хэтрүүлсэн зээлийн түүхгүй;

- Аль нэг банканд өөрийн нэр дээр данс эзэмшдэг, интернэт банкны үйлчилгээ (банкны аппликейшн) ашигладаг;
- Ухаалаг гар утас ашигладаг;
- Үйлчилгээний нөхцөл, Нууцлалын бодлоготой бүрэн танилцаж, зөвшөөрсөн 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол улсын иргэн.

1.6.3. **“Мерчант”** гэж худалдаалж буй бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчид Стор пэй аппликейшнээр дамжуулан худалдан борлуулахаар Компанитай гэрээ байгуулсан хувь хүн, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдийг ойлгоно.

1.6.4. **“Бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ”** гэж хэрэглэгч Мерчантаас худалдан авч өөрийн эзэмшил, ашиглалт, өмчлөлд шилжүүлэх боломжтой Монгол улсын чанар стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан, Монгол улсын хууль тогтоомжоор аливаа хязгаарлалт, хориглолтод ороогүй бүх төрлийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг хэлнэ.

1.6.5. **“Кредит скор”** гэж тусгай аргачлал, компанийн дотоод дүрэм, журам, аргачлалын дагуу хэрэглэгчийн санхүүгийн болон хувийн мэдээлэл, худалдан авалтын эргэн төлөлтийн чадавхыг үнэлж, тогтоосон худалдан авалтын эрсдэлийн үнэлгээг хэлнэ.

1.6.6. **“Үйлчилгээний эрх”** гэж тухайн хэрэглэгчийн бараа, үйлчилгээний худалдан авалтад зориулж үүсгэсэн, худалдан авалтын төлбөрийг амжилттай төлсний дараа дахин ашиглах боломжтой, төгрөгөөр илэрхийлэгдэх үнийн дүнгийн хэмжээ заасан худалдан авалт хийх боломжит эрхийг хэлнэ.

1.6.7. **“SPC токен”** гэж Binance Smart Chain-д суурилсан, BEP20 стандарт бүхий, Компаниас 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр виртуал хөрөнгийн биржээр дамжуулж нийтэд санал болгож худалдсан, виртуал хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж буй, Үйлчилгээнд тухайлсан нөхцөлөөр төлбөрийн зорилгоор ашиглагдах, хэрэглээний токеныг хэлнэ.

1.6.8. **“Тусгай нөхцөл”** гэж тухайлсан Үйлчилгээг авахаас өмнө Та уншиж танилцан, хүлээн зөвшөөрч, шаардлагыг хангасан байх шаардлагатай, Платформд байршуулсан нөхцөлийг ойлгох ба Тусгай нөхцөл болон Үйлчилгээний нөхцөл зөрчилдөх тохиолдолд Тусгай нөхцөлийг баримтална.

1.6.9. **“Хэрэглэгчийн түвшин”** гэж платформоор дамжуулан үйлчилгээний нөхцөлийн дагуу хэрэглэгчийн худалдан авалтын түүхэд суурилан санал болгож буй худалдан авалтын ялгамжтай боломжийг хэлнэ.

1.6.10. **“Зөвшөөрөх үйлдэл”** гэж хэрэглэгч нь Компанид хандан аппликейшн дээр худалдан авах хүсэлт илгээх, эргэн төлөх болон бусад үйлдлийг хүлээн зөвшөөрснөө илэрхийлж буй хэрэглэгчийн үйлдлийг ойлгоно.

1.6.11. **“Хугацаа хэтрүүлсэн төлбөр”** гэж үйлчилгээг ашиглан хийсэн худалдан авалтын төлбөр төлөлтийн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Компаниас худалдан авалтын үнийн дүнгээс хамаарч үйлчилгээний нөхцөлд заасан хэмжээгээр ялгамжтай тогтоосон, хугацаа хэтрүүлсэн төлбөрийг хэлнэ.

Хоёр. Үйлчилгээний нийтлэг нөхцөлүүд

2.1. Үйлчилгээний эрхийн хэмжээ:

2.1.1. Компани нь хэрэглэгчээс ирүүлсэн хүсэлт, санхүүгийн болон хувийн мэдээллийг үндэслэн компанийн баталсан үйлчилгээний нөхцөлийн дагуу үйлчилгээний эрхийг нээнэ.

2.1.2. Компани нь Спор пэй аппликейшнээр дамжуулан 100,000 (нэг зуун мянга) төгрөгөөс 10,000,000 (арван сая) төгрөг хүртэлх худалдан авалтын төлбөрийг хуваан төлөх эрхийг хэрэглэгчид олгоно.

2.1.3. Хэрэглэгч Нийгмийн Даатгалын шимтгэл төлөлтөөр үйлчилгээний эрх нээлгэх хүсэлт гаргасан тохиолдолд компаниас 100,000 (нэг зуун мянга) төгрөгөөс 3,000,000 (гурван сая) хүртэлх төгрөгийн худалдан авалтын төлбөрийг хуваан төлөх эрхийг хэрэглэгчид олгоно.

2.1.4. Хэрэглэгч SPC Wallet-д SPC токен байршуулан үйлчилгээний эрх нээлгэх хүсэлт гаргасан тохиолдолд 100,000 (нэг зуун мянга) төгрөгөөс 10,000,000 (арван сая) хүртэлх төгрөгийн худалдан авалтын төлбөрийг хуваан төлөх эрхийг хэрэглэгчид олгоно.

2.2. Хэрэглэгч өөрийн түвшингээс хамаарч дараах байдлаар худалдан авалтын төлбөрийг хуваан төлнө. Үүнд:

2.2.1. Энгийн түвшний хэрэглэгч дараах худалдан авалтын боломжийг эдэлнэ. Үүнд:

- Худалдан авалтын төлбөрийг шууд төлөх;
- Хүссэн үнийн дүнгээрээ худалдан авалтын төлбөрийн нэхэмжлэл үүсгэж үйлчилгээний эрхээ оролцуулан ашиглах;
- Худалдан авалтын төлбөрөө 4 (дөрөв) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 45 (дөчин тав) хоногийн хугацаанд төлөх.

2.2.2. “Premium” түвшний хэрэглэгч дараах худалдан авалтын боломжийг эдэлнэ. Үүнд:

- Худалдан авалтын төлбөрийг шууд төлөх;
- Хүссэн үнийн дүнгээрээ худалдан авалтын төлбөрийн нэхэмжлэл үүсгэж үйлчилгээний эрхээ оролцуулан ашиглах;
- Худалдан авалтын төлбөрөө 4 (дөрөв) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 45 (дөчин тав) хоногийн хугацаанд төлөх;
- Худалдан авалтын төлбөрөө 3 (гурав) хувааж 30 (гуч) хоногийн зайтайгаар 60 (жар) хоногийн хугацаанд төлөх;

- 2,000,000 төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалтын 50 хувийг урьдчилж төлөөд, үлдэгдэл 50 хувийг 4 хуваан 30 (гуч) хоногийн зайтайгаар 4 (дөрөв) сарын хугацаанд төлөх;
- 1,000,000 төгрөг хүртэлх үнийн дүнтэй худалдан авалтын төлбөрийг төлөхдөө нийт үнийн дүнгийн 25 хувьтай тэнцүү хэмжээний SPC токеныг өөрийн SPC Wallet-д байршуулж, урьдчилгаа төлбөр төлөхгүйгээр 4 (дөрөв) хуваан 60 (жар) хоногийн хугацаанд төлөх.

2.3. Хэрэглэгчийн түвшин дараах байдлаар нэмэгдэж, буурна. Үүнд:

2.3.1. Хэрэглэгч 2 удаагийн худалдан авалтын төлбөрийг амжилттай буюу төлбөрийн хуваарьт заасны дагуу хугацаа хэтрүүлэхгүй төлж дуусгаснаар “Premium” түвшний хэрэглэгч болно.

2.3.2. “Premium” түвшний хэрэглэгч болсноор хуваан төлөх олон төрлийн сонголт, үйлчилгээний эрх илүү өндөр дүнгээр нэмэгдэх боломжтой.

2.3.3. “Premium” түвшний хэрэглэгч 2 худалдан авалт дараалан хугацаа хэтрүүлсэн эсхүл аль нэг худалдан авалтын төлбөрийг 14 хоногоос дээш хугацаагаар хэтрүүлсэн тохиолдолд уг түвшин буурч, үйлчилгээний эрхээ алдана.

SPC токен ашиглагдах үйлчилгээ

2.3.4. Хэрэглэгч Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлсэн, Компанитай хамтын ажиллагаа бүхий виртуал хөрөнгийн бирж (цаашид "Бирж" гэх) дээрх өөрийн хэтэвчинд эзэмшиж буй SPC токеныг Үйлчилгээнд энэ зүйлд заасан хүрээнд ашиглах боломжтой. Компани шаардлагатай тохиолдолд эсхүл эрх бүхий байгууллагын шаардлагаар эдгээр Үйлчилгээний боломжид хэдийд ч өөрчлөлт оруулж болно.

2.3.5. Худалдан авах гэж буй бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн дүнгийн тодорхой хувьд Биржийн хэтэвч дэх өөрийн эзэмшиж буй SPC токеныг үүргийн гүйцэтгэл хангуулах зорилгоор түгжиж тухайлсан Үйлчилгээний эрх нээлгэх боломжтой.

2.3.6. Хэрэглэгч SPC токен ашиглан үйлчилгээний эрх нэмэгдүүлж байгаа тохиолдолд компанийн дотоод дүрэм, журамд хэрэглэгчийн санхүүгийн болон хувийн мэдээлэл, худалдан авалтын мэдээлэл нийцэж байгаа эсэхийг хянах эрхтэй бөгөөд үл нийсэн тохиолдолд татгалзах эрхтэй.

SPC токен ашиглан үйлчилгээний эрхийг дараах нөхцөлөөр нэмэгдүүлнэ. Үүнд:

- *Шинэ хэрэглэгч*- Хэрэглэгч өөрийн SPC Wallet дахь SPC токены хэмжээтэй дүйцэхүйц дүнгээр Үйлчилгээний эрх үүсгэх бөгөөд үүссэн эрх 10,000,000 /арван сая/ төгрөг хүртэл нэмэгдэнэ.
- *3 худалдан авалт хугацаа хэтрүүлэхгүй төлж дуусгасан хэрэглэгч*- Хэрэглэгч өөрийн үйлчилгээний эрхийг нэмэгдүүлэх хэмжээгээр SPC Wallet-д SPC токен байршуулан

байршуулсан SPC токенийн үнийн дүнтэй дүйцэхүйц хэмжээний үйлчилгээний эрхийг 2 нэмэгдүүлнэ.

- *6 худалдан авалт хугацаа хэтрүүлэхгүй төлж дуусгасан хэрэглэгч*- Хэрэглэгч өөрийн үйлчилгээний эрхийг нэмэгдүүлэх хэмжээгээр SPC Wallet-д SPC токен байршуулан байршуулсан SPC токенийн үнийн дүнтэй дүйцэхүйц хэмжээний үйлчилгээний эрхийг 4 нэмэгдүүлнэ.

SPC токен ашиглан нэмэгдүүлсэн үйлчилгээний эрхийг дараах нөхцөлөөр нэмэгдүүлнэ. Үүнд:

- *Шинэ хэрэглэгч*- Хэрэглэгч өөрийн эзэмшиж буй SPC токеныг арилжих, шилжүүлэх зэргээр токены хэмжээ багассан тохиолдолд үйлчилгээний эрхийн хэмжээ анх байсан хэмжээгээр буурна. Үйлчилгээний эрх үүсээгүй хэрэглэгч Үйлчилгээг ашиглах эрх нь хязгаарлагдана.

- *3 худалдан авалт хугацаа хэтрүүлэхгүй төлж дуусгасан хэрэглэгч*- Хэрэглэгч өөрийн эзэмшиж буй SPC токеныг арилжих, шилжүүлэх зэргээр токены хэмжээ багассан тохиолдолд үйлчилгээний эрхийн хэмжээ анх байсан хэмжээгээр буурна.

- *6 худалдан авалт хугацаа хэтрүүлэхгүй төлж дуусгасан хэрэглэгч*- Хэрэглэгч өөрийн эзэмшиж буй SPC токеныг арилжих, шилжүүлэх зэргээр токены хэмжээ багассан тохиолдолд үйлчилгээний эрхийн хэмжээ анх байсан хэмжээгээр буурна.

2.3.7. Хэрэглэгч өөрийн Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хэмжээнд үндэслэн үүссэн эрхээс илүү үнэлгээтэй SPC токен эзэмшиж буй тохиолдолд Үйлчилгээний эрх нэмэгдэх боломжтой бөгөөд бага үнэлгээтэй SPC токен эзэмшиж буй бол эрхийн түвшинд өөрчлөлт орохгүй.

2.3.8. Хэрэглэгч Үйлчилгээ ашигласан худалдан авалтын төлбөрийг амжилттай буюу хугацаа хэтрүүлэхгүй төлж дуусгасан үнийн дүнд SPC токен бодогдон түүний бүртгэлтэй Биржийн хэтэвчинд олгогдоно.

2.3.9. Хэрэглэгч өөрийн эзэмшлийн SPC токеныг энэ Үйлчилгээний нөхцөлд заасан хүрээнд ашиглаж байгаа үед түүний SPC токеныг Биржийн үйлчилгээгээр дамжуулан дараах нөхцөлөөр түгжинэ. Үүнд:

2.3.9.1. Хэрэглэгч үлдэгдэл төлбөр төлөөгүй байгаа худалдан авалтын үнийн дүнд дүйцэх SPC токеныг төлбөрийгтөлж дуусгах хүртэл хугацаагаар;

2.3.9.2. Түгжигдсэн SPC токеныг зөвхөн хэрэглэгч тухайн худалдан авалтыг төлөхөд хүрэлцэж буй нөхцөлд зах зээлийн /market order/ ханшаар арилжих замаар ашиглах боломжтой.

2.3.10. Хэрэглэгч SPC токеныг дээрх хэлбэрээр Үйлчилгээнд ашиглаж буйн төлөө аливаа шимтгэл, хураамж /Бирж үйлчилгээ үзүүлсний төлөө хэрэглэгчээс авах үйлчилгээний шимтгэл үүнд хамаарахгүй/-ийг Компанид төлөхгүй.

2.3.11. Хэрэглэгч өөрийн эзэмшлийн SPC токеныг Үйлчилгээнд ашиглах эсэх шийдвэр гаргахад мэдээлэл өгөх зорилгоор Үйлчилгээний Платформ дээр SPC токены ханшийн мэдээлэл, хэтэвч дэх SPC токены үлдэгдлийн мэдээллийг нээлттэй харуулж болно.

Гурав. Мерчантаас бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах

3.1. Төлбөрийн нэхэмжлэл үүсгэх хэмжээ

3.1.1. Хэрэглэгч платформоор дамжуулан хийх нэг удаагийн худалдан авалтын дүн нь хамгийн багадаа 100,000 /нэг зуун мянга/-аас хамгийн ихдээ 10,000,000 /арван сая/ төгрөг хүртэл хэмжээтэй байна.

3.1.2. Хэрэглэгчийн үйлчилгээний эрхийн боломжит хэмжээ 100,000 /нэг зуун мянга/ төгрөгөөс бага дүнтэй тохиолдолд бэлэн төлөлт оролцуулан 100,000 төгрөгөөс дээш худалдан авалт хийх боломжтой.

3.2. Төлбөрийн нэхэмжлэл үүсгэх

3.2.1. Хэрэглэгч Мерчантаас худалдан авалт хийхдээ дараах байдлаар төлбөрийн нэхэмжлэл үүсгэнэ. Үүнд:

- a. Мерчантаар утасны дугаараар төлбөрийн нэхэмжлэл үүсгүүлэх;
- b. Мерчантын QR кодыг ашиглан төлбөрийн нэхэмжлэл үүсгэнэ.

3.3. Нэхэмжлэлийн дагуу худалдан авалтын төлбөрийг төлөх

3.3.1. Хэрэглэгч Мерчантаас бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахдаа платформд нэвтрэн эхний төлөлтийг хийснээр худалдан авч буй бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүлээж авах боломжтой.

3.3.2. Шинэ хэрэглэгч эхний нэг худалдан авалтыг хуваарийн дагуу амжилттай төлж дуусгасны дараа Үйлчилгээг компаниас тогтоосон үйлчилгээний эрхийн хэмжээнд ашиглах эрхтэй.

3.4. НӨАТ-ын баримт авах

3.4.1. Үйлчилгээг ашиглан хийсэн худалдан авалтын НӨАТ-ын баримтыг тухайн худалдан авалт хийсэн Мерчант олгоно.

3.4.2. Энэхүү үйлчилгээний нөхцөлийн 3.4.1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд НӨАТ-ын баримтыг холбогдох гэрээнд заасны дагуу Компанид олгох зохицуулалттай тохиолдолд хэрэглэгчийн хийсэн худалдан авалтын төлбөр амжилттай төлөгдөж дууссаны дараа Компаниас хэрэглэгчийн бүртгүүлсэн и-мэйл хаягт илгээх болно.

3.5. Мерчантаас бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах

3.5.1. Хэрэглэгчийн Үйлчилгээгээр дамжуулан худалдан авсан бараа, үйлчилгээний чанар, стандарт, доголдлыг тухайн бараа, үйлчилгээг худалдаж буй Мерчант хариуцах бөгөөд доголдолтой холбоотой асуудлыг Мерчанттай холбогдож шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Урамшуулал

4.1. Худалдан авалтаа амжилттай төлж дуусгах бүрд SPC токены урамшуулал 0.5 хувиар тооцож олгох бөгөөд Үйлчилгээний эрхийн хэмжээ нэмэгдэнэ.

4.2. Худалдан авалтын төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд тухайн худалдан авалтад SPC токены урамшуулал бодогдохгүй.

Тав. Хэрэглэгчийн эрх, үүрэг

5.1. Хэрэглэгч нь энэхүү үйлчилгээний нөхцөлийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд Компаниас тогтоосон үйлчилгээний эрхийн хэмжээнд ашиглах, хуваан төлөлтөө төлөх үүргийг хүлээнэ.

5.2. Хэрэглэгч Платформд хувийн болон санхүүгийн мэдээллээ үүсгэх, эсхүл дамжуулахдаа дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

5.2.1. Хуурамч мэдээлэл оруулахгүй байх;

5.2.2. Бусдын хувийн болон санхүүгийн мэдээллийг оруулахгүй байх;

5.2.3. Хугацаа дуусгавар болсон бичиг баримтын мэдээлэл оруулахгүй байх.

5.3. Хэрэглэгч энэхүү үйлчилгээний нөхцөлийн “5.2”-д заасныг зөрчин хуурамч мэдээлэл оруулсан бол Компани нь хэрэглэгчийн үйлчилгээний эрх нээлгэх хүсэлтийг хянах, эсхүл үйлчилгээний эрх нээхээс татгалзах эрхтэй.

5.4. Үйлчилгээний нөхцөлийн “5.2.2”-д заасныг зөрчин бусдын нэр, хувийн болон санхүүгийн мэдээллийг ашигласан, эсхүл дамжуулсан бол Компани нь хэрэглэгчийн үйлчилгээний эрх нээлгэх хүсэлтийг хянах болон үйлчилгээний эрх нээхээс татгалзах эрхтэй бөгөөд та өөрийн хууль бус үйлдлийн улмаас тухайн мэдээллийн өмчлөгч, эзэмшигч, Компанид учруулсан аливаа гэм хор, хохирлыг бүрэн хариуцна.

5.5. Хэрэглэгч нь компаниас тогтоосон үйлчилгээний эрхийн хүрээнд худалдан авалтаа хийх эрхтэй байна.

5.6. Компанийн систем, программын талаар доголдол гарснаас худалдан авалт амжилтгүй болсон, төлбөр төлөлт саатсан зэргээс болж хэрэглэгчийн эрх зөрчигдвөл энэ талаар үйлчилгээ үзүүлэгч талд гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй байна.

5.7. Хэрэглэгч нь Платформд нэвтрэх нэр, нууц үг болон бусад мэдээллийн нууцлалаа чандлан хадгалах бөгөөд нууцлалаа алдсанаас үүсэх хариуцлагыг өөрөө хүлээнэ.

5.8. Хэрэглэгч нь Платформд нэвтрэх нэр болон нууц үгийн нууцлалыг өөрийн эцэг эх, эхнэр/нөхөр, хүүхэд болон бусад этгээдэд санаатай болон санамсаргүй байдлаар задруулсны улмаас үүсэх үр дагаврыг Компани хариуцахгүй болно.

5.9. Хэрэглэгчийн нэвтрэх нэр болон нууц үгийг ашиглан хийгдэж буй аливаа худалдан авалтыг эрх эзэмшигч буюу тухайн этгээд өөрөө хийж буйд тооцно.

5.10. Хэрэглэгч нь Платформд нэвтрэх нууц үгээ алдсан байж болзошгүй тохиолдолд нэн даруй солих үүрэгтэй.

5.11. Хэрэглэгч нь гүйлгээ хийхдээ дансны дугаар, гүйлгээний утга, гүйлгээний дүнгээ зөв оруулах бөгөөд буруу оруулсны улмаас үүсэх зардал, хохирлыг өөрөө хүлээнэ.

5.12. Хэрэглэгч нь Платформд суулгасан гар утас эсхүл төхөөрөмжөө бусдад дамжуулсан, ашиглуулсан, хэрэглүүлсэн, эсхүл хулгайд алдсны улмаас Компанид учирсан хохирол зардлыг бүрэн хариуцна.

5.13. Хэрэглэгч нь Платформ суулгасан гар утас эсхүл төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд үүссэн хохирол зардлыг бүрэн хариуцна.

5.14. Хэрэглэгчийн бүртгэлтэй гар утасны орох эсхүл гарах ярианы эрх нь хаагдсан тохиолдолд үүссэн хохирол зардлыг хэрэглэгч өөрөө хариуцна.

5.15. Хэрэглэгчийн бүртгэлтэй гар утасны дугаар сүлжээнээс гарсан тохиолдолд үүссэн хохирол зардлыг хэрэглэгч өөрөө хариуцна.

5.16. Банкны болон бусад гуравдагч этгээдийн систем, үйл ажиллагааны саатлын улмаас учирсан хохирол, зардлыг Компани хариуцахгүй.

5.17. Хэрэглэгч нь санаатайгаар Платформд системийн доголдол үүсгэсний улмаас үүссэн хохирлыг бүрэн хариуцна.

5.18. Хэрэглэгчийн алдаатай худалдан авалт хийсэн, үйлчилгээний нөхцөлийг бүрэн ойлгоогүй зэрэг хэрэглэгчийн илтэд хайхрамжгүй, болгоомжгүй үйлдэлтэй холбоотой үр дагаврыг Компани хариуцахгүй.

5.19. Тухайн үйлчилгээний нөхцөл буюу хэлцэлд дурдагдаагүй хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

5.20. Хэрэглэгч нь хууль тогтоомж болон үйлчилгээний нөхцөлийн холбогдох заалтуудыг зөрчсөнөөс үүсэх хохирол, аливаа үүргийг дангаар хариуцах үүрэгтэй бөгөөд Компани хариуцахгүй болно.

5.21. Зээлийн мэдээллийн сангаас гаргуулах лавлагааны төлбөрийг хэрэглэгч хариуцна.

Зургаа. Компанийн эрх, үүрэг

6.1. Хэрэглэгчийн үүсгэсэн, дамжуулсан хувийн болон санхүүгийн мэдээллийг хүлээн авч, ашиглах, боловсруулах, хадгалах, цуглуулах эрхтэй.

6.2. Хэрэглэгчийн үүсгэсэн, дамжуулсан хувийн болон санхүүгийн мэдээлэлд хиймэл оюун ухааны тусламжтайгаар дүн шинжилгээ хийх, тэдгээрийн үнэн зөвийг шалгаж баталгаажуулах.

6.3. Хэрэглэгчийн үүсгэсэн, дамжуулсан хувийн болон санхүүгийн мэдээллийг ашиглан худалдан авалт хийх эрхийн хэмжээг тодорхойлох.

6.4. Хэрэглэгчийн төлбөртэй холбоотой санхүүгийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд нийлүүлэх эрхтэй.

6.5. Хэрэглэгчийн фейсбүүк, твиттер профайл найзын жагсаалт болон постыг хуулбарлан авч дүн шинжилгээ хийх, энэхүү үйлчилгээний нөхцөлд заасан зорилгоор ашиглах.

6.6. Энэхүү үйлчилгээний нөхцөлд заасан журмын дагуу цуглуулсан мэдээллийг Компаниас үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шинэ бүтээгдэхүүн гаргахтай холбоотойгоор дотоод хэрэгцээнд ашиглах.

6.7. Энэхүү үйлчилгээний нөхцөлд заасан журмын дагуу цуглуулсан мэдээллийг платформ болон түүний хиймэл оюун ухааныг хөгжүүлэхэд ашиглах.

6.8. Энэхүү үйлчилгээний нөхцөлд заасан журмын дагуу цуглуулсан мэдээллийг Компани нь энэхүү үйлчилгээний нөхцөлийн 6.5-д заасан зорилгоор платформыг хөгжүүлэгч “Ай Си Ти Групп” ХК-д шилжүүлэх, ашиглуулах.

6.9. Компани нь хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, платформыг зүй бусаар, эсхүл хууль бус зорилгоор ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор аппликейшнд хандах хандалт, хэрэглэгчийн хийж байгаа аливаа үйлдлийн түүхийн лог болгон хадгалах, түүнийг хуулийн хүрээнд ашиглах эрхтэй.

6.10. Хэрэглэгч хүлээсэн үүргээ биелүүлээгүй төлөлтийн хугацаа хэтрүүлсэн тохиолдолд хэрэглэгчийн нэр, гэрэл зураг, биелэгдээгүй үүргийн талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, хайх арга хэмжээ авах эрхтэй.

6.11. Үйлчилгээний нөхцөл дээр заасан үүргээ биелүүлэхийг “Токены хэтэвч эзэмшигч”-ээс шаардах эрхтэй.

6.12. Үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт оруулах, шинэчлэх эрхтэй.

6.13. Олон давтамжтай, өндөр дүнтэй мөнгөн болон токен хэлбэрээр гүйлгээ орж гарсан тохиолдолд хэрэглэгчийн эрхийг зогсоож, баталгаажуулахыг шаардах болон шалгах эрхтэй.

6.14. Хэрэглэгчийн токены хэтэвчний мэдээлэл, хэрэглэгчийн оролцоогүйгээр буюу ямарваа нэгэн этгээдэд алдахаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэрэгслийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

6.15. Хэрэглэгчийн хэтэвчний мэдээллийг хамгаалах, нууцлах болон үйлчилгээний нөхцөлд заасан холбогдох хориглох, хаах, хязгаарлах заалтуудыг зөрчсөн тохиолдолд хэтэвчийг хаах эрхтэй.

6.16. Тухайн үйлчилгээний нөхцөл буюу хэлцэлд дурдагдаагүй хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

6.17. Хэрэглэгч нь платформыг дараах зорилгоор ашигласан тохиолдолд урьдчилан сануулалгүйгээр үйлчилгээний эрхийг дахин ашиглах боломжгүйгээр хязгаарлах буюу үйлчилгээг ашиглах эрхийг зогсоох, хаах, шалгах эрхтэй. Үүнд:

6.17.1. Зүй бусаар эсхүл хууль бус зорилгоор ашигласан, ашиглахыг завдсан;

6.17.2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашигласан;

6.17.3. Зориулалтын бусаар ашигласан;

6.17.4. Бусдын хувийн мэдээллийг ашигласан;

6.17.5. Гуравдагч этгээдэд ашиглуулсан, ашиглуулахаар завдсан тохиолдолд;

6.17.6. Хууран мэхлэх, худал мэдээлэлд ашигласан;

6.17.7. Олон нийтийн хэрэгслээр худал, төөрөгдөл үүсгэх мэдээлэл тараахад ашигласан;

6.17.8. Зүй зохисгүй байдлаар, бусдад хохиролтойгоор ашигласан.

6.18 Компани нь хэрэглэгч Платформыг дээрх зорилгоор ашигласан эсэх талаар хуулийн байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шалгуулж, шийдвэрлүүлэх эрхтэй.

6.19. Системд үүссэн доголдол, буруутай мэдээлэл ашиглах болон үүнтэй адилтган үзэх, өөр бусад шалтгаанаар хэрэглэгч болсон тохиолдолд тухайн хэрэглэгчийн эрхийг хаах, зогсоох, шалгах, идэвхтэй худалдан авалт байгаа бол тухайн худалдан авалтын төлбөрийг нэн даруй хэрэглэгчээс шаардаж авах эрхтэй

6.20. Хэрэглэгч нь энэхүү үйлчилгээний нөхцөлд заасан хориглох, хязгаарлах, зогсоох, хаах арга хэмжээ авагдсан шалгагдаж байгаа тохиолдолд дахин эрх үүсгэхгүй байх эрхтэй

6.21. Хэрэглэгч нь системийн хэвийн үйл ажиллагаанд халдах (хакердах) үйлдэл, оролдлого хийсэн тохиолдолд тухайн хэрэглэгчийн эрхийг дахин ашиглах боломжгүйгээр хаах, хязгаарлах эрхтэй

6.22. Хэрэглэгч нь хууль тогтоомж болон үйлчилгээний нөхцөлийн холбогдох заалтуудыг зөрчсөн, зөрчиж магадгүй гэж үзсэн тохиолдолд үйлчилгээг ашиглах эрхийг урьдчилан сануулалгүйгээр зогсоох, хаах, шалгах эрхтэй

Долоо. Худалдан авалтын төлбөрийн хугацаа хэтрэлт

7.1. Хэрэглэгч та энэхүү үйлчилгээний хэрэглэгч болсноор худалдан авалтын төлбөрөө хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах үүрэг хүлээнэ.

7.2. Тус үйлчилгээг ашигласнаар хүү, шимтгэл бодогдохгүй төлбөргүй үйлчилгээ авах бөгөөд зөвхөн төлбөр төлөлтийн хугацаа хэтрүүлсэн тохиолдолд төлөх ёстой төлбөр дээр хугацаа хэтрүүлсний төлбөр , алданги нэмэгдэж бодогдоно.

7.3. Хэрэглэгч төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд худалдан авалтын үнийн дүнгээс хамаарч дараах байдлаар хугацаа хэтрүүлсний төлбөр төлнө. Үүнд:

- 100,000 төгрөгөөс 500,000 төгрөг бүхий үнийн дүнтэй худалдан авалтад 5,000 төгрөг;
- 500,001 төгрөгөөс 1,000,000 төгрөг бүхий үнийн дүнтэй худалдан авалтад 10,000 төгрөг;
- 1,000,001 төгрөгөөс 2,000,000 төгрөг бүхий үнийн дүнтэй худалдан авалтад 20,000 төгрөг;
- 2,000,001 төгрөгөөс 3,000,000 төгрөг бүхий үнийн дүнтэй худалдан авалтад 30,000 төгрөг;
- 3,000,001 төгрөгөөс 4,000,000 төгрөг бүхий үнийн дүнтэй худалдан авалтад 40,000 төгрөг;
- 4,000,001 төгрөгөөс 5,000,000 төгрөг бүхий үнийн дүнтэй худалдан авалтад 50,000 төгрөг;
- 5,000,001 төгрөгөөс 6,000,000 төгрөг бүхий үнийн дүнтэй худалдан авалтад 60,000 төгрөг;
- 6,000,001 төгрөгөөс 7,000,000 төгрөг бүхий үнийн дүнтэй худалдан авалтад 70,000 төгрөг;
- 7,000,001 төгрөгөөс 8,000,000 төгрөг бүхий үнийн дүнтэй худалдан авалтад 80,000 төгрөг;
- 8,000,001 төгрөгөөс 9,000,000 төгрөг бүхий үнийн дүнтэй худалдан авалтад 90,000 төгрөг;
- 9,000,001 төгрөгөөс 10,000,000 төгрөг бүхий үнийн дүнтэй худалдан авалтад 100,000 төгрөг.

7.4. Хэрэглэгч тухайн хуваарьт төлөлтөө 7 хоногийн дотор төлөөгүй бол 7.3-т заасан хэмжээгээр хугацаа хэтрүүлсний төлбөр дахин нэмэгдэнэ.

7.5. Худалдан авалтын хамгийн сүүлийн төлөлт хийх хугацаанаас 14 хоног хэтрүүлсэн бол дараагийн өдрөөс хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алданги болон хугацаа хэтрүүлсний төлбөр дээр нэмж тооцогдоно.

7.6. Төлбөр төлөлтийн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Үйлчилгээний эрхийг тухайн төлөлтийг бүрэн төлөх хүртэл хугацаагаар зогсоох бөгөөд төлөлт хийснээр Үйлчилгээг үргэлжлүүлэн ашиглах эрхтэй болно.

7.7. Төлбөр төлөлтийн хугацааг хэтрүүлсэн хоног, авагдсан арга хэмжээнээс хамаарч зогсоох, хаах, ахин ашиглуулахгүй байх шийдвэрийг “Стор Пэй” ХХК дангаар шийдвэрлэнэ.

7.8. Хэрэглэгч нь төлбөр төлөх хугацаагаа хэтрүүлсэн тохиолдолд Стор пэй ХХК-аас хугацаа хэтэрсэн хэрэглэгчийн санхүүгийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх.

Найм.Үйлчилгээний эрсдэл

8.1. Хэрэглэгчийн хувийн болон санхүүгийн мэдээлэл, худалдан авалтын түүхэд үндэслэж худалдан авалтын эрхийг хэмжээг тогтоох бөгөөд энэ нь хэрэглэгчийг аливаа өрийн дарамтад оруулахгүй гэх баталгаа болохгүй.

8.2. Хэрэглэгч банк, банк бус санхүүгийн байгууллага, гуравдагч этгээдээс авсан зээлийн эргэн төлөлт хийх үүрэг хүлээсэн үйлчилгээний хэрэглээгээ тооцоолж, худалдан авалтыг хийх үүрэг хүлээнэ.

8.3. Хэрэглэгчид SPC токенд суурилсан үйлчилгээг санал болгох бөгөөд SPC токенд суурилсан виртуал хөрөнгийн үйлчилгээг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн виртуал хөрөнгийн бирж үзүүлэх ба уг биржээс авч буй виртуал хөрөнгийн үйлчилгээ болон SPC токен виртуал хөрөнгө болохын хувьд гарах аливаа эрсдэлийг Компани хариуцахгүй.

Ес. Хэрэглэгчийн мэдээллийн нууцлал ба хэрэглэгчийн санал, хүсэлт

9.1. Үйлчилгээнд бүртгүүлэх, Платформд нэвтрэх, Үйлчилгээ авах явцад Хэрэглэгч болон түүний хандалтын талаарх тодорхой мэдээлэл, бичиг баримтууд болон хэрэглэгчийн хувийн мэдээллийг Компани Нууцлалын бодлогын дагуу цуглуулж, боловсруулж, ашиглана.

9.2. Энэхүү үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч, үйлчилгээг ашиглаж байгаа нь хэрэглэгчийн хувийн мэдээллийг Нууцлалын бодлогод заасны дагуу ашиглахыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ. Нууцлалын бодлоготой танилцана уу.

9.3. Хэрэглэгч info@storepay.mn и-мэйл хаягаар, албан ёсны нийгмийн сүлжээний сувгууд болон 7611-0111 дугаарын утсаар долоо хоногийн бүх өдрүүдэд 09:00-22:00 цагийн хооронд Үйлчилгээтэй холбоотой мэдээлэл авах, санал хүсэлт гаргах боломжтой.

Арав. Холбоос

10.1. Платформд Мерчант эсхүл Компанитай хамтран ажиллагч гуравдагч этгээдийн вэбсайтын холбоосыг мэдээллийн эсхүл сурталчилгааны зорилгоор байрлуулж болох бөгөөд эдгээр вэбсайт нь Компанийн хяналтаас гадуур байх тул тэдгээр гуравдагч талын вэбсайт дээрх аливаа контенттой холбоотойгоор Компани үүрэг, хариуцлага хүлээхгүй.

Арван нэг. Үйлчилгээний оюуны өмчийн хамгаалалт

11.1. Платформ дээрх контент /агуулга/ болон зохиогчийн эрх, барааны тэмдэг, худалдааны нууц зэрэг бүх төрлийн оюуны өмч, тэдгээрийг ашиглах онцгой эрх нь Компани эсхүл тухайн оюуны өмчийн эрх эзэмшигчид хадгалагдана. Контент гэдэгт Платформ дээрх мэдээлэл, өгөгдөл, технологийн хэрэгсэл, код, хэв загвар, аппликейшн, санаа, ноу-хау, лого, бичвэр, дүрс, зураг, бичлэг, дизайн, бүтээгдэхүүн, үйлчилгээ, шийдэл, шаардлага, сурталчилгааны материал болон тэдгээрт хэвлэгдсэн бүх төрлийн бичгийн болон мультимедиа материал зэрэг бүх контент хамаарна.

11.2. Хэрэглэгч нь Контентыг Компаниас урьдчилан олгосон бичгийн зөвшөөрөлгүйгээр ашиглахгүй бөгөөд мэдээ, материал эсхүл Контентыг зүй зохисгүйгээр ашиглах, Компани эсхүл түүний харьяа байгууллага, захирлууд болон ажилтнуудад аливаа хохирол учруулах санаа, зорилго агуулахгүй болно.

11.3. Хэрэглэгч нь Компанитай өрсөлдөх зорилгоор Контентод аливаа хяналт тавих, ашиглах, хуулбарлах, худалдах, өөрчлөх эсхүл ашиглах үйлдэл гаргахгүй. Энэ Нөхцөлийн

дагуу Платформыг ашиглахаас бусад тохиолдолд хэрэглэгч нь Контентод хамаарах аливаа төрлийн эрх эдлэхгүй. Зөвшөөрөлгүй ашигласан эсхүл хуулбарласан тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ.

11.4. Компанийн оюуны өмчид хамаарах заалтыг хэрэглэгч зөрчсөн тохиолдолд түүний үр дагаварт учирсан хохирол, нөхөн төлбөрийг хариуцна.

Арван хоёр. Хүчин төгөлдөр болох

12.1. Хэрэглэгч үйлчилгээний нөхцөлтэй танилцаж, бүрэн ухамсарлаж ойлгож хүлээн зөвшөөрсөнөөр тус хэлцэл хүчинтөгөлдөр болно.

НУУЦЛАЛЫН БОДЛОГО

Энэхүү Нууцлалын бодлогоор “Стор Пэй” ХХК-ийн үйлчилгээ (цаашид “Үйлчилгээ” гэх)-ний Хэрэглэгч (цаашид “Хэрэглэгч” гэх)-ийн мэдээлэл (хэрэглэгч хувь хүн бол хувийн мэдээлэл, байгууллага бол байгууллагын мэдээллийг хамааруулна)-ийг цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулна.

Бид Хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй, халдашгүй байдлыг эрхэмлэх бөгөөд Нууцлалын бодлогоор зохицуулаагүй харилцаанд Монгол Улсын Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

Хэрэглэгч та “Стор Пэй Үйлчилгээний нөхцөл”, “B2B Үйлчилгээний нөхцөл”, “Нууцлалын бодлого”-той бүрэн танилцаж, ойлгосны үндсэн дээр Хэрэглэгчийн мэдээллийг Мэдээлэл хариуцагчид цуглуулах, боловсруулах, ашиглах зөвшөөрөл олгох эсэхийг хараат бусаар, бие даан шийдвэрлэнэ үү.

Хэрэв хэрэглэгч танд Нууцлалын бодлогын аль нэг нөхцөл, заалт ойлгомжгүй буюу тодруулах шаардлагатай гэж үзвэл Үйлчилгээний Хэрэглэгчээр бүртгүүлэхээс өмнө info@storepay.mn хаяг руу хандаж тодруулга авна уу.

Нууцлалын бодлогод тусгасан нөхцөлүүдийг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа тохиолдолд “Зөвшөөрч байна” гэсэн хэсгийг идэвхжүүлснээр Бидэнд Хэрэглэгчийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглах цахим зөвшөөрлийг олгосон гэж үзнэ.

1. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үндэслэл, зорилго

1.1. Бид Нууцлалын бодлогын дагуу Хэрэглэгчийн мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрлөөр цуглуулж, боловсруулж, ашиглана.

1.2. Үйлчилгээг ямар нэгэн саадгүйгээр Хэрэглэгчид шууд хүргэх, хэрэглэгчийн бүртгэлийг үүсгэх, бүртгэл хөтлөх, танин баталгаажуулах (KYC) зорилгоор Хэрэглэгчийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглана.

1.3. Нууцлалын бодлогод заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:

1.3.1. “Хэрэглэгчийн мэдээлэл” гэж Хэрэглэгчийг таньж, тодорхойлох боломжтой шууд болон шууд бус мэдээллийг ойлгоно. Тухайлбал, хувийн мэдээлэл гэж иргэн бол овог, нэр, төрсөн огноо, газар зүйн байршил, иргэний бүртгэлийн дугаар, боловсролын мэдээлэл, гишүүнчлэлийн мэдээлэл, хуулийн этгээд бол нийтэд нээлттэйгээс бусад үйлчилгээнд бүртгүүлэх болон үйлчилгээг авах явцад гаргаж өгсөн, бүрдүүлсэн баримт бичиг, болон цахим тодорхойлогчийг;

1.3.2. “Мэдээлэл цуглуулах” гэж мэдээллийг олж авах, бүрдүүлэх, бүртгэх үйл ажиллагааг;

1.3.3. “Мэдээлэл боловсруулах” гэж мэдээллийг ангилах, хадгалах, дүн шинжилгээ хийх, хэрэглэгчийн хүсэлтээр өөрчлөх, устгах, сэргээх үйл ажиллагааг;

1.3.4. “Мэдээлэл ашиглах” гэж Мэдээлэл хариуцагч үйл ажиллагаандаа хэрэглэх, дамжуулах болон мэдээлэлтэй танилцах үйл ажиллагааг;

1.3.5. “Мэдээлэл хариуцагч” гэж Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн “Стор Пэй” ХХК байна.

1.4. Бид Үйлчилгээг сайжруулах зорилгоор Хэрэглэгчийн мэдээллийг нэмэлтээр цуглуулж болно.

2. Цуглуулах, боловсруулах, ашиглах мэдээллийн жагсаалт

2.1. Бид Хэрэглэгчийн мэдээллийг “Storepay” аппликейшныг ашиглах, түүгээр дамжуулан үйлчилгээг үзүүлэх явцад цуглуулж, боловсруулж, ашиглана.

2.2. Хэрэглэгч “Storepay”-д (төхөөрөмжөөр) нэвтэрсэн үеэс эсхүл Мэдээлэл хариуцагчаас санал болгож буй үйлчилгээг ашиглах бүрд Хэрэглэгчийн мэдээллийг цуглуулна.

2.3. Хэрэглэгч мэдээллээ бүрэн бүтэн, үнэн, зөв оруулах үүрэгтэй. Хэрэв Хэрэглэгчийн мэдээллийг буруу, дутуу эсхүл зөрүүтэй оруулсан тохиолдолд Үйлчилгээг ашиглах боломжгүй болохыг анхаарна уу.

2.4. Бид Хэрэглэгчийн дараах хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглана. Үүнд:

2.4.1. Үйлчилгээг ашиглах үед Хэрэглэгчээс “Storepay” аппликейшнд оруулсан дараах мэдээллүүд:

2.4.1.1. Хэрэглэгчийг танин баталгаажуулах зорилгоор бүртгэл үүсгэхэд Хэрэглэгчийн буюу хувь хүний оруулсан овог, нэр, төрсөн он сар, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа хаяг, одоо цагийн өөрийн зураг, гар утасны дугаар, цахим шуудангийн хаяг, иргэний үнэмлэхийн зураг, гарын үсэг, баримт бичиг болон тэдгээрт агуулагдаж буй бусад мэдээллүүд (Зарим мэдээллүүдийг ХҮР системээр дамжуулан баталгаажуулах).

2.4.1.2. Хэрэглэгчтэй холбогдох боломжгүй болсон тохиолдолд эсхүл яаралтай үед холбогдох 2 хүний овог, нэр, утасны дугаар гэх зэрэг мэдээллүүд (Хэрэглэгчтэй яаралтай үед холбогдох 2 хүний мэдээллийг оруулсан тохиолдолд тус 2 хүнээс зөвшөөрөл олгосон гэж үзнэ);

2.4.1.2. Хэрэглэгч үйлчилгээтэй холбоотой аливаа төрлийн электрон төхөөрөмж ашиглаж “Стор пэй”-ийн цахим хуудас болон олон нийттэй харилцдаг сувгуудаар дамжуулан холбогдоход ашиглагдсан таны хаяг зэрэг мэдээллүүд;

2.4.2. Хэрэглэгч үйлчилгээг ашиглах явцад үүсэх мэдээллүүд:

2.4.2.1. Банкны данс, кредит болон дебит карт, гүйлгээний түүх, худалдан авалт, худалдан авалтын төлбөр төлөлтийн мэдээлэл, санхүүгийн тайлан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэл, SPC токен байршуулах, байршуулж буй виртуал хөрөнгийн хэтэвчний мэдээлэл, SPC токенд суурилсан аливаа үйлчилгээ авч буй бол тэдгээрийн мэдээллүүд (Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг ХУР системээр дамжуулан баталгаажуулах).

2.4.2.2. Үйлчилгээ болон SPC токенд суурилсан аливаа үйлчилгээг ашиглах явцад үүссэн мэдээллүүд;

2.4.2.3. Хэрэглэгчийн бүртгэлд хамаарах нууц үг, бүртгэлийн дугаар, баталгаажсан э-мэйл хаяг, худалдан авалтын гүйлгээний нууц үг зэрэг мэдээллүүд;

2.4.2.4. Хэрэглэгчээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдол, түүнийг шийдвэрлэхэд хамаарах мэдээллүүд;

2.5. Бид Үйлчилгээгээ илүү энгийн хялбар болгохоор хөгжүүлж, боловсронгуй болгохоос гадна “Storepay” аппликейшнд хандсан зөвшөөрөлгүй хандалтыг тодорхойлох үүднээс Хэрэглэгчийн дараах мэдээллүүдийг тухай бүр автоматаар цуглуулж болно. Үүнд:

2.5.1. Газар зүйн байршил, ашиглаж буй үйлдлийн систем, веб хөтчийн нэр, IP хаяг, цахим протокол, “Storepay” аппликейшнд нэвтэрсэн хугацаа.

2.5.2. Хэрэглэгчийг баталгаажуулах код, гүйлгээний код, бүртгэлийн мэдээлэл, бусдад хуваалцсан болон сэтгэгдэл үлдээсэн мэдээллүүд;

2.5.3. Хэрэглэгчийн тогтмол ашигладаг төхөөрөмжийн мэдээлэл болон тухайн төхөөрөмж дээр хийсэн үйлдлүүдийн мэдээлэл;

2.5.4. Cookies файлын тусламжтайгаар (вэбсайт эсхүл төхөөрөмжийн хөтөч дээр хадгалагдсан мэдээлэл, хандсан мэдээллийн эх сурвалж) цуглуулсан мэдээллүүд;

2.6. Cookies, web beacons болон бусад ижил төрлийн файлуудын тусламжтай дараах мэдээллийг цуглуулах бөгөөд тус харилцааг “Cookies бодлого”-оор зохицуулна. Үүнд:

2.6.1. Бид боломжит хүрээнд cookies болон ижил төрлийн файлуудад зөвшөөрөлгүй нэвтрэх, хандалт хийхээс сэргийлнэ. Тусгайлан танин баталгаажуулагчаар дамжуулан Бид эсвэл үйлчилгээ үзүүлэгч Cookies мэдээлэлд хандах эрхтэй байна.

2.6.2. “Storepay” аппликейшнд нэвтрэх үед хийж буй тогтмол үйлдэл, үйлчилгээний сонголтын бүртгэлийн мэдээлэл;

2.6.3. Cookies файлыг ашиглаж Google stat-аар дамжуулан Үйлчилгээний мэдээллийг бүртгэж, цахим зар сурталчилгааг хэрэглэж буй байдал;

2.6.4. “Storepay” аппликейшнд нэвтэрсэн байдлыг хэвээр хадгалж буй тохиолдлууд;

3. Мэдээлэл боловсруулах, ашиглах

3.1. Бид Хэрэглэгчийн хэрэгцээнд тулгуурлан Үйлчилгээг байнга сайжруулах, хөгжүүлэх, боловсронгуй болгох, кибер халдлага болон бусад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, залилан мэхлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээнд Хэрэглэгчийн мэдээллийг дараах тохиолдлуудад боловсруулж, ашиглана. Үүнд:

3.1.1. Үйлчилгээг удирдан зохион байгуулах, хөгжүүлэх, хэрэглэгч бүрд хүргэх хүрээнд:

3.1.1.1. Хэрэглэгчийг танин, баталгаажуулах явцад;

3.1.1.2. Хэрэглэгчийн худалдан авалт хийх эрх нээх эсэх шийдвэр гаргах явцад;

3.1.1.3. Үйлчилгээг сайжруулах судалгааг хийх болон судалгаанаас гарсан дүгнэлтийг хэрэгжүүлэх бүрд;

3.1.1.4. Үйлчилгээг хүргэх бүрд;

3.1.1.5. Гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний үүргийг хэрэгжүүлэх хүрээнд;

3.1.1.6. “Storepay” платформыг хөгжүүлэх зорилгоор;

3.1.1.7. Маркетингийн үйл ажиллагаа зохион байгуулах тохиолдолд;

3.1.1.8. Худалдан авалт хийх үед мэдээллийг шилжүүлэх, баталгаажуулах бүрд;

3.1.1.9. Үйлчилгээний нөхцөлд заасан эрх, үүргийн хэрэгжилтэд аудит хийх явцад;

3.1.1.10. Үйлчилгээний талаарх мэдээллийг Хэрэглэгчид цахимаар болон утсаар холбогдож хүргэх бүрд;

3.1.1.11. Хэрэглэгчийн хүссэн бусад Үйлчилгээг үзүүлэх хүрээнд;

3.1.1.12. Үйлчилгээний шинэчлэл, сайжруулалтын мэдээллээр хангах хүрээнд;

3.1.2. Залилан мэхлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх хүрээнд:

3.1.2.1. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор;

3.1.2.2. Үйлчилгээнд холбогдох асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор;

3.1.2.3. Үйлчилгээний аюулгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хамгаалах ажлыг зохион байгуулах зорилгоор;

3.1.2.4. Хэрэглэгчээс ирүүлсэн болон Хэрэглэгчид холбогдох гомдлыг хянан шалгах зорилгоор;

3.1.2.5. Хэрэглэгчийн мэдээллийн үнэн зөв байдлыг шалгах, шаардлагатай тохиолдолд гуравдагч этгээдээс өгсөн мэдээлэлтэй харьцуулан шалгах зорилгоор;

3.1.2.6. Аудитын шалгалт болон хууль, шүүхийн байгууллагаар хэрэг маргааныг хянан шалгах, шийдвэрлэх хүрээнд;

4. Мэдээллийг нийтэд ил болгох нөхцөл

4.1. Хуульд заасан тохиолдолд зөвхөн төрийн эрх бүхий байгууллагын шаардлагаар хэрэглэгчийн мэдээллийг нийтэд ил болно.

4.2. Хуульд өөрөөр заагаагүй бол 4.1-т зааснаас бусад тохиолдолд бид хэрэглэгчийн мэдээллийг задруулахгүй бөгөөд мэдээллийн нууцыг хамгаална.

5. Мэдээллийг дамжуулах

5.1. Хэрэглэгч өөрийн хүлээн зөвшөөрсөн үйлчилгээний нөхцөлийг зөрчиж худалдан авалтын төлбөр төлөлтийн хугацаа хэтрүүлсэн бол хэрэглэгчийн мэдээллээс шаардлагатай мэдээлэл /нэр, гэрэл зураг, биелэгдээгүй үүрэг гэх мэт үүгээр хязгаарлагдахгүй/-ийг хууль, шүүхийн болон холбогдох байгууллагад дамжуулна.

5.2. Мэдээлэл хариуцагч нь хэрэглэгчийн мэдээллийг “Storepay” аппликейшнийн тасралтгүй, найдвартай, хэвийн ажиллагааг хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шинэ бүтээгдэхүүн гаргахтай холбоотойгоор дараах мэдээллийг цахим платформ хөгжүүлэгч “Ай Си Ти Групп” ХК-д дамжуулна. Үүнд:

5.2.1. Хэрэглэгчийг танин баталгаажуулах зорилгоор бүртгэл үүсгэхэд Хэрэглэгчээс оруулсан овог, нэр, төрсөн огноо, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа хаяг, тухайн өдрийн бодит зураг, гар утасны дугаар, цахим шуудангийн хаяг, иргэний үнэмлэхийн зураг, гарын үсэг, бусад баримт бичиг болон тэдгээрт агуулагдаж буй болон бусад мэдээллүүд;

5.2.2. Банкны данс, кредит болон дебит карт, гүйлгээний түүх, худалдан авалт, худалдан авалтын төлбөр төлөлтийн мэдээлэл, санхүүгийн тайлан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэл, SPC токен байршуулж буй байршуулах виртуал хөрөнгийн хэтэвчний мэдээлэл, SPC токенд суурилсан аливаа үйлчилгээ авч буй бол тэдгээрийн мэдээллүүд;

5.2.3. Үйлчилгээ болон SPC токенд суурилсан аливаа үйлчилгээг ашиглах явцад үүссэн мэдээллүүд;

5.2.4. Хэрэглэгчийн бүртгэлд хамаарах нууц үг, бүртгэлийн дугаар, баталгаажсан э-мэйл хаяг, худалдан авалтын гүйлгээний нууц үг зэрэг мэдээллүүд;

5.2.5. Хэрэглэгчээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдол, түүнийг шийдвэрлэлтийн байдалд хамаарах мэдээллүүд;

5.2.6. Газар зүйн байршил, ашиглаж буй үйлдлийн систем, веб хөтчийн нэр, IP хаяг, цахим протокол, “Storepay” платформд нэвтэрсэн хугацаа;

5.2.7. Хэрэглэгчийг баталгаажуулах код, гүйлгээний код, бүртгэлийн мэдээлэл, бусдад хуваалцсан болон сэтгэгдэл үлдээсэн мэдээллүүд;

5.2.8. Хэрэглэгчийн тогтмол ашигладаг төхөөрөмжийн мэдээлэл болон тухайн төхөөрөмж дээр хийсэн үйлдлүүдийн мэдээлэл;

5.2.9. Cookies файлын тусламжтайгаар (вэбсайт эсхүл төхөөрөмжийн хөтөч дээр хадгалагдсан мэдээлэл, хандсан мэдээллийн эх сурвалж) цуглуулсан мэдээллүүд;

5.2.10. “Storepay” платформд нэвтрэх үед хийж буй тогтмол үйлдэл, үйлчилгээний сонголтын бүртгэлийн мэдээлэл;

5.3. Бид эрх бүхий байгууллагаас шаардсанаас бусад тохиолдолд Хэрэглэгчийн мэдээллийг аливаа хэлбэрээр гуравдагч этгээдэд дамжуулахгүй, шилжүүлэхгүй, худалдахгүй.

6. Мэдээлэл боловсруулах, ашиглах, хадгалах хугацаа

6.1. Хэрэглэгчийн гүйлгээ, төлбөр төлөлттэй холбоотой мэдээллийг компьютерын хамгаалалтын системд хадгална.

6.2. Бид хэрэглэгчийн мэдээллийн бүрэн бүтэн байдал алдагдах, бүртгэлд зөвшөөрөлгүй нэвтрэх, мэдээллийг задруулах эрсдэлийг бууруулах үүднээс техник технологийн шийдэл болон аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллана.

6.3. Хэрэв хэрэглэгч өөрийн хайхрамжгүй үйлдлээс болж “Storepay” аппликейшнд нэвтрэх мэдээллээ алдсан эсхүл бусдад өөрийн мэдээллээ шилжүүлсэн, ашиглуулсан тохиолдолд үүсэх үр дагаврыг хэрэглэгч өөрөө хариуцна. Хэрэглэгч “Storepay” платформд нэвтрэх нэр, нууц үг, баталгаажуулах код зэрэг өөрийн мэдээллийг бусдад дамжуулахгүй, нийтэд мэдээлэхгүй байх арга хэмжээг авах.

6.4. Хэрэв хэрэглэгч хувийн мэдээллээ алдсан эсхүл гуравдагч этгээд хэрэглэгчийн бүртгэлд нэвтэрсэн байх тохиолдолд хэрэглэгч мэдсэн даруй цаг алдалгүй бидэнд энэ талаар мэдэгдэх үүрэгтэй.

6.5. Кибер халдлага, системийн гэмтэл, албан тушаалтны алдаатай үйл ажиллагаа, эсхүл программ хангамж болон мэдээллийн санд гэмтэл гарсны улмаас хэрэглэгчийн мэдээлэл алдагдсан тохиолдолд бид хэрэглэгчийн бүртгүүлсэн э-мэйл хаяг, гар утасны дугаарт нэн даруй мэдэгдэл хүргүүлнэ. Хэрэглэгч мэдэгдэлд заасан заавар, анхааруулгын дагуу арга хэмжээ авах үүрэгтэй.

6.6. Харилцаа холбооны интернэт сүлжээ, э-мэйл, утасгүй сүлжээ, зурвас болон мессенжерээр дамжуулан хэрэглэгчээс илгээж буй мэдээллийн аюулгүй байдлыг бид хангах боломжгүй. Хэрэглэгчийн илгээсэн мэдээллийг бид хүлээн авахаас өмнө биднээс үл хамаарах шалтгаанаар алдагдаж болзошгүй болохыг мэдэгдэж байна.

6.7. Мэдээлэл хариуцагч нь хэрэглэгчийн мэдээллийг хугацаагүйгээр хадгална.

6.8. Бид Үйлчилгээг сайжруулах зорилгоор Хэрэглэгчийн лавлах утсанд холбогдсон дуудлагын бичлэгийг 14 хоногийн хугацаагаар хадгална.

7. Насанд хүрээгүй хүний хувийн мэдээллийг хамгаалах

7.1. Мэдээлэл хариуцагч нь 18 насанд хүрээгүй иргэний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж, хадгалахгүй бөгөөд энэ тохиолдлыг мэдсэн бол үйлчилгээг шууд зогсоож, мэдээллийг устгах арга хэмжээг яаралтай авна.

7.2. Хэрэв хэрэглэгч “Storepay” платформоос санамсаргүй байдлаар насанд хүрээгүй хүний мэдээллийг цуглуулсан гэж үзэж байгаа бол бидэнд яаралтай хүсэлт гаргах эрхтэй бөгөөд хүсэлт гаргасан тохиолдолд эдгээр мэдээллийг устгах арга хэмжээг авна.

8. Хэрэглэгчийн мэдээллийн эрхийн хамгаалалт

8.1. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хэрэглэгч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

8.1.1. Бүртгэлийг устгах хүсэлт гаргах болон цаашид хэрэглэгчийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахгүй байхыг шаардах;

8.1.2. “Storepay” платформ дахь өөрийн хувийн мэдээлэлтэй танилцах;

8.1.3. Хэрэглэгчийн хувийн мэдээллийг боловсруулах, ашиглахыг хуульд заасны дагуу ашиглахыг шаардах;

8.1.4. Өөрийн хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд Мэдээлэл хариуцагчид мэдэгдэх;

8.1.5. Хуульд заасан үндэслэлээр тодорхой хувийн мэдээллийг өөрчлөх, засварлах, устгахыг шаардах;

8.2. Хэрэглэгчийн гаргасан Хэрэглэгчийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглах, цахим зөвшөөрлийг цуцлах хүсэлтийг Мэдээлэл хариуцагч ажлын 14 хоногийн дотор судалж, “Storepay” аппликейшнээс бүртгэл, мэдээллийг устгаад хариу мэдэгдэх болно.

8.3. Хэрэв Хэрэглэгч энэхүү Нууцлалын бодлогын дагуу бүртгэлээ устгуулсан тохиолдолд Үйлчилгээг ашиглах боломжгүй бөгөөд Хэрэглэгчийн хүсэлтийг хүлээн авсан эсэхээс үл хамаарч хүсэлт гаргахаас өмнө цуглуулсан Хэрэглэгчийн мэдээллийг Нууцлалын бодлогод заасан хугацаагаар хадгална.

9. Нууцлалын бодлогын шинэчлэлт

9.1. Үйлчилгээг үзүүлж байх хугацаанд Нууцлалын бодлогод нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлд өөрчлөлт орсон зохицуулалтыг дагаж мөрдөнө.

9.2. Энэхүү бодлогод нэмэлт, өөрчлөлт орсноос хойш Хэрэглэгч үйлчилгээг хэрэглэсээр байгаа бол нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

9.3. Бид Нууцлалын бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулсан даруйд Storepay.mn вэбсайтын нүүр хэсгийн хамгийн доор байрлах “Нууцлалын бодлого” хэсэгт, “Storepay” аппликейшн цэсэд байрлах “Нууцлалын бодлого” хэсэгт тус тус Хэрэглэгчид зориулж нээлттэй нийтэлнэ.

9.4. Хэрэглэгч болон Мэдээлэл хариуцагчийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэхэд “Сторпэй” үйлчилгээний нөхцөл болон энэхүү Нууцлалын бодлогыг баримтална.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО

“Стор пэй” ХХК-ийн Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны бодлого нь дэвшилтэт технологиор дамжуулан үзүүлж буй санхүүгийн үйлчилгээ, хэрэглэгч, хамтран ажиллаж буй байгууллагын мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор MNS ISO/IEC 27001:2023 стандартын дагуу Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хянах, тасралтгүй сайжруулахыг зорино.

Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо нь дараах бодлогыг баримтална. Үүнд:

1. Нууцлал: Мэдээллийн нууцлалыг хангахдаа “Нууцлалын бодлого”-д тодорхойлсны дагуу хэрэгжүүлнэ.
2. Хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлага: Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Монгол улсын хууль, зохицуулагч байгууллагын мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой дүрэм, журам, стандартын шаардлагын нийцлийг хангана.
3. Бизнесийн тасралтгүй үйл ажиллагаа: Компанийн хэрэглэгч, хамтран ажиллаж буй байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлж бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг хангахыг зорих бөгөөд шаардлагатай технологи, хүний нөөц болон санхүүгийн нөөцөөр тогтмол хангана.
4. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага: Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг тодохойлох, үнэлэх, түүнийг зөв зохистой удирдах бүхий л харилцааг MNS ISO/IEC 27001:2023 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартад нийцүүлэн хэрэгжүүлнэ.
5. Хэрэгжилт: Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хэрэгжилт, үр дүнг жилд хамгийн багадаа нэг удаа тооцож сайжруулалт хийдэг байна.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ, НУУЦЛАЛЫН БОДЛОГО БОЛОН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГОТОЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРӨВ.

"СТОП ПЭЙ" ХХК